

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 11 дүгээр
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хамтарсан хуралдаанаараа явуулж, нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусгасан төслийн эцсийн хувилбарыг танилцуулгын хамт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан “Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд 31,600.0 тэрбум төгрөг гэснийг 490.0 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2026 онд 32,980.0 тэрбум төгрөг гэснийг 490.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон харгалзах дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувьд өөрчлөлт оруулах” гэсэн саналд үндэслэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон төсвийн тусгай шаардлагад нөлөөлөхөөр байна гэж дүгнэсэн.

Уг дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.5 дахь заалтын дагуу Байнгын хороодын хамтарсан хуралдаанд багш нарын цалинг нэмэгдүүлэхтэй холбогдуулан 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд холбогдох өөрчлөлтийг хийх талаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан саналтай холбогдсон тооцооллыг дахин нягтлах чиглэл өгч, төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулахаар буцаасан.

Байнгын хороод 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хамтарсан хуралдаанаар хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-т заасны дагуу явуулсан бөгөөд уг хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Д.Үүрийнтуяа нар Улсын Их Хурлаар төсвийн тухай хуулийн төслүүдийг хэлэлцэхэд холбогдох хуульд нийцээгүй, хууль зөрчсөн саналуудаар санал хураалт явуулахгүй байхад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн зардлуудыг нэмж болохгүйг сануулж, зардал нэмэгдүүлэх саналыг эх үүсвэртэй нь

уялдуулан гаргадаг байх, Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа цалин, тэтгэвэр нэмэгдүүлж байгаатай холбогдуулан инфляц өсөж болзошгүй учраас Монголбанк, Эдийн засаг, хөгжлийн яамнаас инфляцийг нэмэгдүүлэхгүй байхад анхаарч ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан Улсын Их Хурлаар дунд хугацааны төсвийн төсөөллийг хэлэлцүүлэхгүй, зөвхөн тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэн баталдаг байх нь зүйтэй талаар үг хэллээ.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлгээр багш, эмч, эмнэлгийн ажиллагсад, төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагын ажилчдын цалин болон тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх асуудал шийдэгдэхээр болсонтой холбогдуулан төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд холбогдох өөрчлөлтүүдийг оруулах нь зүйтэй гэсэн санал гаргасныг Байнгын хороодын хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Х.ГАНХУЯГ

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

Ч.ЛОДОЙСАМБУУ